



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, 9.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 13 дугаар тогтоол, тус яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга

Төрийн нарийн бичгийн дарга

Зөвлөлийн гишүүд

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Хуулийн хэлтсийн дарга

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга

Сансрын холбооны хэлтсийн дарга

993935

Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга

Цахим засаглалын хэлтсийн дарга

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга

Зөвлөлийн нарийн бичиг

Төрийн захиргааны удирдлагын газрын Төлөвлөгөө, тайлангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх “Удирдлагын зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Жавхлан/-д үүрэг болгосугай.

4. Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА,



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
08 дугаар сарын 18-ны өдрийн 186 дугаартай
тушаалын хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ДЭРГЭДЭХ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх удирдлагын зөвлөл /цаашид “Удирдлагын зөвлөл” гэх/-ийн хурлыг тус яамны үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын шуурхай байдлыг хангах, яамны эрхлэх үйл ажиллагааны хүрээнд тулгамдсан зорилтыг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад зөвлөх зорилгоор зохион байгуулна.
- 1.2 Энэ журмаар удирдлагын зөвлөлийн хэлэлцэх асуудал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой зөвлөлийн хурлын дэгийг тогтооно.
- 1.3 Удирдлагын зөвлөлийн үйл ажиллагаа нь хууль дээдлэх, хамтын удирдлагын ил тод байдал, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

**Хоёр. Удирдлагын зөвлөлийн
үйл ажиллагааны зохион байгуулалт**

- 2.1 Удирдлагын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Хурлын шийдвэр нь тэмдэглэл байна.
- 2.2 Хурлыг Төрийн нарийн бичгийн дарга даргална.
- 2.3 Хурлын зохион байгуулалт, бэлтгэлийг хангах асуудлыг Төрийн захиргааны удирдлагын газраас эрхлэн гүйцэтгэнэ.
- 2.4 Хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний төслийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга урьдчилан танилцаж хянасны дараа Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна.
- 2.5 Хурлыг сард 2 удаа зарлан хуралдуулах ба Төрийн нарийн бичгийн даргын саналаар хугацааг тухай бүрд товлох ба ажлын зайлшгүй шаардлагаар товлосон хугацаанд хурлыг хийж чадахгүйд хүрвэл хугацааг өөрчилж, дахин товлоно.
- 2.6 Зөвлөлийн гишүүн нь албан ажлын болон хувийн шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлын нарийн бичигт урьдчилан мэдэгдэж, хурал даргалагчаас чөлөө авсан байна.
- 2.7 Хурлыг гишүүдийн 70-аас дээш хувь нь ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 2.8 Хурлын хэлэлцэх асуудлын шаардлагыг харгалзан Зөвлөлийн гишүүдээс гадна салбарын болон харьяа байгууллагын төлөөлөл, зөвлөх, мэргэжилтнийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.
- 2.9 Зөвлөлийн гишүүн хуралд дараах эрх, үүргийг хэрэгжүүлэн оролцоно:
 - 2.9.1 хэлэлцэж байгаа асуудлын талаар санал, дүгнэлт гаргах;
 - 2.9.2 хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцсан байх;